

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн “Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/16/НА-СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллагын үйл ажилагаа	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4. Аудитын тайлан	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Дотоод хяналт	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт	12
8.1 Залруулсан алдаа.....	12
8.3 Албан шаардлага.....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
10. Аудитын тайлангийн хавсралт	15
10.1. Албан шаардлага	15
10.2. Албан шаардлага	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.22 № 264
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Н.ГАНБААТАР
ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий аймгийн Дархан сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Дархан сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бараа материалын тооллогыг биетээр хийгээгүй, 25.2 сая төгрөгийн хангамжийн материал дансны үлдэгдлийг тоолоогүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай холбогдох заалтад нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайланг хугацаа: 2021. 12. 31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	21,072,505.7	63,375,328.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,985,960.85	37,486,349.42
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	17,985,960.85	37,486,349.42
3121	Төгрөг	17,985,960.85	37,486,349.42
31213	Арилжааны банк дахь харилцах	17,985,960.85	37,486,349.42
33	АВЛАГА	423,694.89	715,478.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	288,352.89	-
335	Бусад авлага	135,342.00	715,478.80
3351	Байгууллагаас авах авлага	135,342.00	715,478.80
35	БАРАА МАТЕРИАЛ	2,662,850.00	25,173,500.00
354	Хангамжийн материал	2,662,850.00	25,173,500.00
35410	Бичиг хэргийн материал	15,850.00	-
35420	Аж ахуйн материал	2,647,000.00	25,173,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,112,760,804.00	1,298,833,771.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,112,760,804.00	1,298,833,771.80
392	Биет хөрөнгө	1,111,400,804.00	1,297,745,771.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	979,790,004.00	981,790,004.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(55,568,100.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	125,160,000.00	125,160,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(25,032,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,158,000.00	18,308,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(960,666.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,292,800.00	3,292,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,269,599.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	253,940,645.01
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,915,310.57)
393	Биет бус хөрөнгө	1,360,000.00	1,087,999.96
39301	Програм хангамж	1,360,000.00	1,360,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(272,000.04)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,133,833,309.74	1,362,209,100.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	90,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	90,000.00
413	Өглөг	-	90,000.00
41310	Ажитчидтай холбогдсон өглөг	-	90,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,133,833,309.74	1,362,119,100.02
51	Засгийн газрын хувь оролцоо	1,133,833,309.74	1,362,119,100.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	1,355,889,649.01
51101	Өмч: - төрийн	-	1,355,889,649.01
512	Хуримтлагдсан үр дүн	1,133,833,309.74	6,229,451.01
51210	Өмнөх үеийн үр дүн	1,133,833,309.74	28,884,305.74
51220	Тайланг үеийн үр дүн	-	(22,654,854.73)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,133,833,309.74	1,362,209,100.02

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэ	Төгрөгөөр /Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	1,216,726,754.00	306,178,957.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,216,726,754.00	306,178,957.52
120	Нийтлэг татварын бус орлого	1,216,726,754.00	306,178,957.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,104,950,004.00	21,450,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,104,950,004.00	2317 21,450,000.00
120009	Бусад орлого	29,871,440.00	СНӨААТҮГ 48,120,600.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/		236,608,357.52
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	82,893,444.26	328,833,812.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,893,444.26	328,833,812.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,893,444.26	328,833,812.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,165,312.00	104,803,078.00
210106	Ажлагчдад төлсөн /ТӨҮГ/	32,165,312.00	104,803,078.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,272,879.59	14,663,781.18
210201	Тэтгэврийн даатгал	2,651,088.71	
210202	Тэтгэмжийн даатгал	316,636.35	
210203	ҮОМШӨ-ний даатгал	253,309.08	
210204	Ажилгүйдлийн даатгал	51,845.45	
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	14,663,781.18
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,455,252.67	124,349,275.86
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		124,349,275.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	85,017,677.21
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	85,017,677.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,133,833,309.74	(22,654,854.73)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,133,833,309.74	(22,654,854.73)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Бусад хувь оролцооны нийт дүн	
					Засгийн газрын	/төгрөгөөр /
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	2317141297	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	СЧА0245 9074082	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	1,133,833,309.74	1,133,833,309.74	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,133,833,309.74	-	1,133,833,309.74
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	1,133,833,309.74	-	1,133,833,309.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,104,949,004.00)	(1,104,949,004.00)	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	28,884,305.74	-	28,884,305.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	1,355,889,649.01	-	-	-	1,355,889,649.01
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	(22,654,854.73)	(22,654,854.73)	-
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,355,889,649.01	-	6,229,451.01	-	1,362,119,100.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	111,776,750.00	269,970,557.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	111,776,750.00	269,970,557.52
120	Нийтлэг татварын бус орлого	111,776,750.00	269,970,557.52
120009	Бусад орлого	29,871,440.00	33,362,200.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	81,905,310.00	236,608,357.52
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	91,953,989.15	250,470,168.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,953,989.15	250,470,168.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,953,989.15	250,470,168.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,916,760.00	92,225,618.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	26,916,760.00	92,225,618.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,379,229.00	26,904,420.18
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	7,379,229.00	26,904,420.18
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,658,000.15	131,340,130.77
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	57,658,000.15	131,340,130.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,822,760.85	19,500,388.57
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,836,800.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,836,800.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,836,800.00	-
223001	Бусад хөрөнгө	1,836,800.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,836,800.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,985,960.85	19,500,388.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		17,985,960.85
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,985,960.85	37,486,349.42

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хэнтий аймгийн “Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь “Хоггүй тохилог орчныг бид бүрдүүлнэ” гэсэн зорилготой ажиллаж байна. Дархан сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нэгдсэн халаалт, хуурай хог хаягдлын цэвэрлэгээ, нохой устгал, бохир ус зайлуулах, авто замын хадгалалт хамгаалалт, гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хортон халдваргүйжүүлэлт, ундны цэвэр усан хангамж, ачаа тээвэр, бусад үйлчилгээг /эд хөрөнгө, машин техник, тоног төхөөрөмжийн түрээс гэх мэт/ үзүүлнэ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийг 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд. Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх. 77.4-т “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18.0	37.5	19.5
Авлага	0.4	0.7	0.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	2.7	25.2	22.5
Үндсэн хөрөнгө	1,112.8	1,298.8	186.1
Нөөцийн бараа	-	-	-
Нийт хөрөнгө	1,133.8	1,362.2	228.4
Өр төлбөр	-	0.1	0.1
Засгийн газрын оролцоо	1,133.8	1,362.1	228.3
Засгийн газрын оролцоо/Өмч - Төрийн/	-	1,355.9	1,355.9
Өмнөх үеийн үр дүн	1,133.8	28.9	(1,104.9)
Тайлант үеийн үр дүн	-	(22.7)	(22.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,133.8	1,362.2	228.4

Банк дахь мөнгөний үлдэгдэлд арилжааны банк дахь харилцах дансанд байгаа 37.5 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд байгууллагаас авах 0.7 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25.2 сая төгрөг болж 22.5 сая төгрөгөөр өссөн нь Дархан сумын ЗДТГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө данс худалдаж авсан 20.1 сая, Дархан сумын ЗДТГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 250.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд НДШ-ийн 0.1 сая төгрөгийн өр төлбөр байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,355.9 сая төгрөг болж өссөн нь аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн 981.8 сая төгрөгийн уурын зуух, сумын ОНХС-аас 125.2 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, сумын ЗДТГ-аас 249.5 сая төгрөгийн үнэ бүхий халуун ус, цэцэрлэгт хүрээлэн, худгийг шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хэнтий аймгийн “Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь 2021 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Гүйцэтгэлээр 306.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 328.8 сая төгрөгийн зардал гарган, 22.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн “Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн “Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

“Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын удирдлага нь дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баталж мөрдөөгүй байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба “Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Дархан сумын Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 329.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тус байгууллага нь шилэн дансны сайтад бүртгүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шинээр байгуулагдсан тул өмнөх оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,136.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,104.9 сая төгрөгийн алдааг залруулж, 31.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Залруулагдаагүй 25.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 2.5 сая төгрөгийн түвшинээс 22.7 сая төгрөгөөр их байгаа тул Хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,104.9 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:

- Өмнөх онд аймгийн ОНХС-аас үндсэн хөрөнгө дансанд шилжүүлсэн уурын зуухны 979.8 сая, сумын ОНХС-аас шилжүүлсэн тээврийн хэрэгслийн 125.2 сая, нийт 1,104.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж өмнөх үеийн үр дүнг өсгөсөн байна. Засгийн газрын сан дансанд бүртгэж өмнөх үеийн үр дүнд залруулсан.

8.3 Албан шаардлага

Аудитаар 31.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Зардлыг хэмнэлгүй шагналд 1.0 сая, оюутны сургалтын төлбөрт 5.0 сая, нийт 6.0 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Бараа материал дансны үлдэгдэлд байгаа 25.2 сая төгрөгийн хангамжийн материалыг тоолж тооцоо бодоогүй.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Запуулга		Акт		Үүнээс		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	Хэнтий аймгийн "Дархан сумын Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	ХЭА-2022/16/НА-СТА-ОНӨААТҮГ	Төрөөс олгосон 1,104.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж өмнөх үеийн үр дүнг өсгөсөн	Засгийн газрын сан дансанд бүртгэж өмнөх үеийн үр дүнд залруулсан.	1	1,104.9	1	1,104.9									
2	Хэнтий аймгийн "Дархан сумын Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	ХЭА-2022/16/НА-СТА-ОНӨААТҮГ	Зардлыг хэмнэлгүй шагналд 1.0 сая, оюутны сургалтын төлбөрт 5.0 сая, нийт 6.0 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан	Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн	1	6.0					1	6.0					
3	Хэнтий аймгийн "Дархан сумын Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ	ХЭА-2022/16/НА-СТА-ОНӨААТҮГ	Бараа материал дансны үлдэгдэлд байгаа 25.2 сая төгрөгийн хангамжийн материалыг тоолж тооцоо бодоогүй.	Бараа материалын тооллогыг хууль тогтоомжийн дагуу чанартай хийж, тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулах	1	25.2					1	25.2					
ДҮН					3	1,136.1	1	1,104.9			2	31.2					



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 22

Дугаар 180/А2370452
ХТХ - 2022/16/НА ЕТХ - ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материал дансны үлдэгдэлд байгаа 25.2 сая төгрөгийн хангамжийн материалыг жилийн эцсээр тоолж тооцоо бодоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ -ын дарга Н.Ганбаатар, нягтлан бодогч Г.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ХУЛАНХАТАН

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 22

Дугаар 181/А2370452
ХТН 2022/16/НА-ЕТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дархан сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зардлыг хэмнэлгүй шагналд 1.0 сая, оюутны сургалтын төлбөрт 5.0 сая, нийт 6.0 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.3-т "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ -ын дарга Н.Ганбаатар, нягтлан бодогч Г.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Б.ХУЛАНХАТАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

2317141297
СХА0046 9074082